

**ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛ, ХҮҮХДИЙН ЭСРЭГ ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ
ДЭД ЗӨВЛӨЛИЙН 2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ**

2024 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр

Сайншанд сум

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Зорилтод түвшин	Хэрэгжилтийн тайлан
1	Хууль зүй, дотоод хэргийн салбарын байгууллагуудын эцэг, эхийн зөвлөлөөр дамжуулан гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сургалт зохион байгуулах	Сургалтыг 1 удаа зохион байгуулсан байх	Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын хүүхэд хамгааллын улсын байцаагч Б.Энхтуяагаар алба хаагчдад “Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь” сэдэвт сургалт зохион байгуулсан ба тус хэлтсийн сумдын 14 албан хаагч цахимаар, төвийн 15 албан хаагч танхимаар хамрагдсан.
2	Байгууллагын албан хаагчдын хөгжлийн бэрхшээлтэй хүний талаарх ойлголтыг дээшлүүлэх чиглэлээр сургалт зохион байгуулах	Сургалтыг 1 удаа зохион байгуулсан байх	Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын Халамжийн хэлтсийн дарга Ч.Долгормаагаар “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах нь” сургалтыг зохион байгуулсан ба тус хэлтсийн сумдын 14 албан хаагч цахимаар, төвийн 15 албан хаагч танхимаар хамрагдсан. Мөн тус хэлтэст хөгжлийн бэрхшээлтэй 2 албан хаагч болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй 1 албан хаагч ажилладаг ба тэдгээрийн эрхийг хангах, тусламж дэмжлэг үзүүлэх талаарх ойлголтыг дээшлүүлсэн.
3	Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр бэлтгэж буй аливаа контентуудыг хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүртээмжтэй хэлбэрээр бэлтгэж түгээх	Мэдээлэл түгээсэн байх	Хэлтсийн үйлчилгээний зааланд байрших иргэдэд мэдээлэл түгээх дэлгэцээр улирал тутам 7 хоног Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлийн контентийг байршуулж бүртгэлийн үйлчилгээ авч байгаа иргэдэд түгээж байна.
4	Цахим орчинд хүүхдийн эрхийг хамгаалах, зохистой хэрэглээний талаар иргэд, олон нийтийг мэдээллээр хангах	Мэдээллээр хангасан байх	Цахим орчинд хүүхдийн эрхийг хамгаалах, зохистой хэрэглээний талаарх гарын авлага, брошурыг хэлтсийн үйлчилгээний зааланд байршуулж иргэдэд тараасан.

ТАЙЛАН БИЧСЭН:
УЛСЫН БҮРТГЭГЧ

Г.НАНДИН-ЭРДЭНЭ

ТАЙЛАН ХЯНАСАН:
ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.ТЭГШЖАРГАЛ

